



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №26



2018 оны 7-р сарын 30-наас, 8-р сарын 03-ны хооронд

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **1111** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 99(8.9%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1001(90.2%) хачигт халдвар, 2(0.2%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 6(0.5%) боом, 2(0.1%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1001** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17.1%-иар буурсан, эпидемиологийн 30-р долоо хоногтой харьцуулахад 20 сэжигтэй тохиолдлоор их байна.



8 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар хачигт риккетсиозын 744 сэжигтэй тохиолдлын 178(23.9%), хачигт энцефалитын 171 сэжигтэй тохиолдлын 32(18.7%), хачигт боррелиозын 86 сэжигтэй тохиолдлын 23(26.7%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 113 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **99** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14%-иар буурсан, эпидемиологийн 30-р долоо хоногтой харьцуулахад 8 эрсдэлд өртсөн тохиолдлоор их байна.



1.3 Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:


Баянхонгор аймгийн Баянцагаан суманд тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, тархвар судлал, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна.

1.4 Мэрэгч амьтны дуудлага:

8 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийслэлийн ЧД-ийн Шарга морьт, “Гоодойн-Ам” гэдэг газар, СХД-ийн Цагдаагийн I-р хэлтсээс ирүүлсэн амьтны дуудлаганд 3 удаа үйлчилсэн. Он гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 32 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Тарваган тахлын дархлаажуулалтын хамралт:

Улсын хэмжээнд тарваган тахлын дархлаажуулалтын аян 90.4 хувийн хамралттай, амжилттай явагдаж дууслаа.



ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Улаанбаатар хотын ХУД-ийн 13-р хорооны Туул тосгонд оршин суудаг. Өвчтөн “Б” 6 настай, эрэгтэй. 7 дугаар сарын 28-нд гэрийхээ гадаа адуунд хазуулсан. Адууны эзэн нь тодорхойгүй. Адууг 2 хоног уяж хяналтад байлгасан боловч 30-нд үхсэн байна. 8 дугаар сарын 03-ны байдлаар хүүхдийн биеийн байдал сайн, 03-нд галзуугийн эсрэг вакцины гурав дахь тунд хамрагдана.

Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:

- 7 сарын 28-нд ГССҮТ-д үзүүлэн шархны цэгцлэлт хийлгэн, галзуугийн эсрэг вакцины эхний тун, 7 сарын 30-нд хоёр дахь тунд хамрагдсан
- 7 сарын 30-нд ЗӨСҮТ-өөс 5.3 мл ийлдэс хүргүүлж, ийлдэс эмчилгээ хийж эхэлсэн
- 7 сарын 30-нд адууны тархи, нугаснаас авсан сорцонд Нийслэлийн Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний дүнгээр мал, амьтны галзуу өвчин болох нь батлагдсан
- Голомтод байгаа 261 үхэр, 13 нохой, 58 гахай, 2 адуунд галзуугийн вакцин хийгдсэн
- 8 дугаар сарын 2-нд голомтонд байгаа 10 хүнд галзуугийн эсрэг вакцин хийгдсэн
- ЗӨСҮТ дуудлагыг хүлээн авч нөхцөл байдлыг тодруулж, Хан-Уул дүүргийн Эрүүл мэнд нэгдэл, Туул тосгоны өрхийн эмнэлэгтэй мэдээлэл тогтмол солилцон, ажиллаж байна. Эко, SBN, Ийгл, UBS телевизэд галзуу өвчний талаар тодруулга, сэрэмжлүүлэг ярилцлага өгсөн.

Олон улсад:

Эбола вирүст халдвар:

Сьерра Леоне улсын Засгийн газраас Эбола вирүсийн шинэ зүйлийг сарьсан багваахайнаас илрүүлсэн тухай мэдэгджээ. Тус вирүсийг анх илрүүлсэн газар болох Сьерра Леоне улсын хойд хэсгийн дүүргийн нэрээр Bombali вирүс хэмээн нэрлэсэн байна. Энэхүү вирүсээр хүн халдвар авсан тухай баримт нотолгоо байхгүй боловч, Байгаль орчны EcoHealth холбоо ашгийн бус байгууллага хүний эсийг халдварлуулах боломжтой тухай мэдэгдсэн байна.



Эх сурвалж: <https://www.statnews.com/>

Эбола вирүст халдвар:

БНАК Улсад Эбола вирүст халдварын дэгдэлтийг таслан зогсоосныг 7 дугаар сарын 24-нд дэлхий нийтэд албан ёсоор зарласан боловч, **БНАК улсын Уганда улстай хил залгаа Хойд Киву мужид** (сая гаруй хүн амтай) Эбола вирүст халдварын сэжигтэй 6 хүнээс 4 нь эбола вирүсийн халдвартай болох нь тогтоогдсон тухай Нийслэл хот дах Био-Анагаах ухааны судалгааны үндэсний хүрээлэнгээс мэдээлсэн байна.



Тус газар тандалт судалгаа, нэмэлт шинжилгээнүүд хийгдэж байна. ДЭМБ бусад хөрш орнуудыг анхаарал болгоомжтой, хариу арга хэмжээ авах бэлтгэлтэй байхыг сануулсан байна.

Эх сурвалж: ДЭМБ


Шүлхий өвчин: Зимбабве улс

Зимбабве улсын Машоналанд мужийн малын аж ахуйд шүлхий өвчин бүртгэгдэж, 2000 үхэр өртсөнөөс, 22 үхэр өвчилсөн байна. Тус мужийн 38000 үхэрт вакцинжуулалт хийгджээ.

Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин: ОХУ


ОХУ-ын Москва мужид Африкийн гахайн мялзан өвчний улмаас 32 гахай өртсөнөөс, 3 гахай өвчилж үхэн, 29 гахайг устгасан байна. Голомтот тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Мал, амьтны галзуу өвчин: Норвеги улс

Норвеги улсын Свалбард Ян Майен мужид RABV хэвшлийн вирусээр үүсгэгдсэн мал, амьтны галзуу өвчин бүртгэгдэж 1 цаа бугыг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Жич: Энэ долоо хоногт **Архангай, Баянхонгор, Багануур, Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Завхан, Төв** аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн eor@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?